

АНУ-ЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА (ADJUDICATION BY PLEA)

Ч. Хосбаяр¹

АНУ-ын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шүүхийн ажиллагаа нь шүүхэд шилжиж буй яллагдагч холбогдсон хэрэгтээ гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч байгаа эсэхээс хамааран “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” эсвэл “Шүүх хуралдаанаар шүүн таслах ажиллагаа” гэсэн хоёр өөр хэлбэрээр үргэлжилдэг. Шүүгдэгч тухайн гэмт хэргийг үйлдээгүй болохоо илэрхийлсэн тохиолдолд шүүх хуралдаан хийж шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоодог, харин гэм буруугаа хүлээн зөвшөөрч буй тохиолдолд ял наймаацах байдлаар буюу хялбаршуулсан журмын хүрээнд хэргийг шийдвэрлэдэг. Бидний ярилцах сэдэвт сүүлчийн хэлбэр нь хамааралтай.

Гэм буруутай эсэх тухай яллагдагчийн байр суурь (Plea)

Прокуророос үйлдсэн яллах дүгнэлттэй танилцсан яллагдагчаас шүүх түүнийг шүүхэд шилжүүлэхээс өмнө прокурорын яллах дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг асуудаг. Бүх муж улсад яллагдагч энэ талаар гэм буруутай (Guilty Pleas), эсвэл гэм буруугүй (Not Guilty Pleas) гэсэн мэдэгдэл хийхийг зарим муж улсад тодорхой бус мэдэгдэл (Nolo Contendere Pleas) хийхийг зөвшөөрдөг.

“Агуулга тодорхой бус” мэдэгдэл

Латинаар Nolocontendere гэх энэ мэдэгдэл нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч буй мэдэгдлийн нэг хэлбэр бөгөөд яллагдагч өөрийн үйлдлийг үгүйсгэхгүй байгаа боловч өөрийгөө гэм буруугүй (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй) гэж үзэж буй гэсэн үг. АНУ-ын шүүхийн практикт яллагдагч нь гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын нөхөн төлбөрийн асуудлыг өөрт ашигтай шийдвэрлүүлэх зорилгоор дээрх мэдэгдлийг ихэвчлэн хийдэг. Эрүүгийн хэрэгт гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын талаар хүлээх эд хөрөнгийн хариуцлага шууд үүсдэг байхад эрүүгийн хэрэгтээ nolo contendere мэдэгдэл гаргасан шүүгдэгчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх эсэх нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар жич шийдвэрлэгддэг. Өөрөөр хэлбэл иргэний хэрэгт гэм буруутай эсэх, эд хөрөнгийг хариуцлага хүлээлгэх үндэслэлийг дахин тогтоодог. Энэ үедээ иргэний шүүх өмнө эрүүгийн шүүх хуралдаанаас гарсан шийдвэрийг чухал ач холбогдолтой гэж үздэггүй нь шүүгдэгчид ашигтай байдаг аж.

“Гэм буруугүй” мэдэгдэл

Гэм буруутай гэсэн мэдэгдлийг хөнгөн, хүндэвтэр хэргийн (misdemeanor) яллагдагч өөрсдийгөө хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар шийтгүүлэх боломжтой гэж үзэж гаргадаг бол гэм буруугүй мэдэгдлийг ихэвчлэн хүнд, онц хүнд хэрэгт холбогдсон хорих ялаар шийтгүүлэх магадлал өндөр яллагдагч гаргадаг. Энэ тохиолдолд тангарагтан нарыг байлцуулан ердийн журмаар эрүүгийн шүүх хуралдааныг явуулж шүүгдэгчийн гэм буруугийн асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ гэсэн үг. Яллагдагч, шүүгдэгч мэдэгдэл гаргахаас татгалзсан, эрх зүйн чадамжийн хувьд бүрэн бус, эсвэл байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчгүй оролцож буй үед шүүх

¹ МУИС, ХЗС-ийн докторант, шүүгч

түүнийг гэм буруугүй гэсэн мэдэгдэл гаргасан гэж үзэж хэргийг заавал тангарагтны шүүх хуралдаанаар хэлэлцүүлдэг байна.

Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл

Шүүх ийм мэдэгдэл хийж буй яллагдагчид эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай байх, энэ мэдэгдлийн агуулга, гарах үр дагаврын талаар өмгөөлөгчтэй зөвлөлдсөн, ойлгож мэдсэн, зөвхөн сайн дурын үндсэн дээр уг мэдэгдлийг гаргахаар шийдсэн байх шаардлага тавьдаг.

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх

талуудын сонирхол ба ял наймаацах

(The philosophy of plea bargaining)

Шүүгдэгчийн холбогдсон гэмт хэргийн зүйлчлэл, ялын асуудлаар шүүгдэгчийн өмгөөлөгч, улсын яллагч хоёр нэг шийдэлд хүрэхээр хэлэлцээр хийхийг ял наймаацах гэдэг. Талууд хэргийн үйлдлийн тоо, зүйлчлэл, ялын хэмжээн дээр тохиролцож болдог. Шүүгдэгч хэд хэдэн гэмт хэрэгт холбогдсон үед тэдгээрийн нэг хэсэгт гэм буруутайгаа хүлээсэн тохиолдолд бусад хэсэгт яллахгүй байхаар тохирохыг хэвтээ буюу горизонталь, гэмт хэргийн зүйлчлэл дээр, тухайлбал шүүгдэгч тодорхой гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрвөл уг гэмт хэрэгт хамаарч болох илүү хүнд зүйл эсвэл хэсгээр яллахгүй байхыг босоо буюу вертикаль тохироо, мөн зөвхөн оногдуулах ялын хэмжээг багасгаж тохиролцохыг ял тохирох гэж нэрлэдэг. Хэд хэдэн ноцтой үйлдэл бүхий гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгчийн хувьд дээрх гурван төрлийн тохироо зэрэг явагдах боломжтой.

Гэм буруугийн асуудлаар тохиролцох нь яллах болон өмгөөлөх чиг үүрэг баримтлах талуудад аль алинд нь доорх шалтгаанаар ашигтай байдаг.

Талуудын хувьд шүүх хуралдаан нь эрсдэл агуулдаг

Хэдийгээр шүүх хуралдаан дээр өмгөөлөх болон яллах талын хэн нь ялах нь хэрэгт цугласан нотлох баримтаас багагүй хамаарах боловч мэтгэлцээнийг төгс хэрэгжүүлдэг АНУ мэтийн улсад энэ нь талуудын мэтгэлцэх чадвараас голчлон шалтгаалдаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл хэрэгт буй нотлох баримтад тулгуурлан шүүх хуралдаанаас гарах шийдвэрийг урьдаас таамаглах боломжгүй, зарим тохиолдолд баримжаагаар төсөөлж болох боловч талуудын мэтгэлцэх ур чадвараас хамаараад хэргийн эцсийн зүйлчлэл, оногдуулах ялын төрөл, хэмжээ зэрэг яаж өөрчлөгдөхийг яг таг таах боломжгүй учир шүүх хуралдаанаар хэргийг эцэслэн шийдвэрлэх нь аль ч талын хувьд зохих хэмжээний эрсдэлийг заавал дагуулдаг гэж үздэг ажээ.

Zero-sum game гэдэг нь аль нэг талын хожлын хэмжээ нөгөө талын хожигдолтой (алдагдалтай) тэнцүү, тэдгээрийн нийлбэр “тэг” байх дүрмийг хэлдэг. Энэ дүрмээр мөн нэг талын хожих магадлал, нөгөө талын алдах магадлалтай ч тэнцүү байна гэж үздэг. Аливаа мөрийтэй тоглоом, дайн байлдаанаас гадна шүүх хуралдаан зэрэг мэтгэлцээн, тэмцээнийг шууд ил хэрэгжүүлдэг давтагдах шинжтэй үйл ажиллагаанд энэ дүрэм үйлчилдэг бөгөөд талууд асар их зардал, цаг хугацаа зарцуулсны эцэст гарах үр дүн тэр бүр тодорхойгүй, хэлж тааварлах боломжгүй, өндөр эрсдэл дагуулдгаас байнга нэг нэгнийгээ бүрэн ялж буулгаж авахын төлөө эцсээ хүртэл хүч шавхан хоорондоо тулалдахын оронд аль алиных нь ашиг сонирхолд нийцэх дундын шийдвэр дээр шууд тохиролцсон нь хамаагүй дээр гэсэн үзэл санаа давамгайлж ирдэг байна. Өөрөөр хэлбэл шүүх хуралдаан хийж талууд мэтгэлцэж тэмцэлдсэнээр аль нэг тал нь өөрийн ашиг сонирхолд бүрэн нийцсэн шийдвэр шүүхээр гаргуулж нөгөө талаа нухчин дарах гэж мэрийхийн оронд хэн нь ч энэ ялагдсан тал байх эрсдэл бий гэдгийг ойлгож харилцан нэг нэгэндээ зарим буулт хийж тал бүрийн ашиг сонирхолд дундаж хэмжээгээр нийцэх нэг шийдэлд хүрэх нь илүү ухаалаг явдалд тооцогддог ажээ. Энэ замыг сонгон авч тохиролцоонд хүрсэн талууд богино хугацаанд бага зардлаар өөрсдийн зорилгын заримд нь ч гэсэн хүрсэндээ бүгдээрээ сэтгэл хангалуун байх нь олонтаа. Чухам энэ л яллах, өмгөөлөх

талуудыг ял наймаацахад түлхдэг гол учир шалтгаан мөн. Үүнээс гадна өө ямар шалтгаан байдгийг авч үзье.

Шүүх дэх хэргийн ачаалал (Case Loads)

Талууд гэм буруугийн асуудлаар тохиролцохыг АНУ-ын шүүхээс зөвшөөрөх, бүр дэмжих хандлагатай байдгийг шүүхийн хэргийн ачаалалтай холбож тайлбарлах нь түгээмэл. Шүүх асар олон тооны хэргийг аль болох богино хугацаанд бодитой шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд талууд шүүгдэгчийн гэм буруу болон оногдуулах ялын асуудлаар тохиролцож ирсэн тохиолдолд хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэх байдлаар хэргийн дарамтаас гарахыг зорьдог гэж үзэх нь олонтаа. Гэтэл энэ чиглэлээр судалгаа хийсэн зарим эрдэмтэд талууд гэм буруугийн асуудлаар тохиролцсон байх нь шүүхийн хэргийн ачааллыг нимгэлдэг нь үнэн боловч энэ нь түүнийг дэмждэг гол шалтгаан биш болохыг тогтоожээ. АНУ-ын эрдэмтэн Милтон Хьюман² 1880 оноос 1954 оны хооронд АНУ-д шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоонд судалгаа хийж шүүгдэгч гэм буруугаа хүлээгээгүй учир хэргийг тангарагтан оролцуулж бүрэн хэмжээний шүүх хуралдаан хийж шийдвэрлэсэн тохиолдол 1910 он хүртэл бүх хэргийн дөнгөж 20 хувь байгаад, түүнээс хойш 10 хувиас хэтрэхгүй болж улам цөөрснийг олж мэдсэнээс гадна хамгийн чухал нь хэргийн ачаалал багатай орон нутгийн шүүхүүдийн хувьд ч энэ харьцаа ойролцоогоор хадгалагдаж байгааг ажиглаад шүүх хэрэгтээ дарагдсандаа болоод хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэхийг дэмждэг биш, угаасаа талууд уг журмыг илүү сонирхдогт учир байна гэж дүгнэсэн байна. Мөн судлаач Майкл Томпсон³ АНУ-ын 5 муж улсын янз бүрийн шатны шүүхээр шийдэгдсэн хэрэг дээр хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн тоо тухайн шүүхийн хэргийн ачааллаас хэрхэн хамаарч байгааг тусгайд нь судалж үзээд хэргийн ачаалал ихтэй шүүхүүдийн хувьд хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэх нь арай түлхүү байж 90 хувь хүрэх боловч бусад ачаалал багатай шүүхүүдэд ч энэ нь 80 хувиас буухгүй байгааг харьцуулаад хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх сонирхлыг өдөөгч хүчин зүйлүүдэд хэргийн ачааллын шалтгаан бага хувь эзэлж үүнээс өөр бусад шалтгаанууд голлож байгааг олж тэмдэглэсэн байна. Эдгээр шалтгаанууд нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч талуудын зорилго, хүсэл зоригтой шууд холбоотой бөгөөд тэдгээрийг дэлгэрэнгүй авч үзье.

Прокуророос хамааралтай хүчин зүйлс (The Prosecutor's Objectives)

Прокурор шүүгдэгчийн өмгөөлөгчтэй хэлцэл хийхдээ “тухайн хэрэг дээр шүүгдэгч өөрийгөө гэм буруугүй гэж үзэж прокурортой маргаж шүүх хуралдаанд орж эцэст нь гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхээр тогтоогдвол шүүх прокурорын санал болгож байсан ялаас илүү хүнд ял шийтгэдэг” гэсэн зарчмын ойлголт дээр тоглодог. Үнэхээр ч ийм практик АНУ дахь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тогтсон байдаг

Прокурорыг ял тохиролцоход хүргэх олон шалтгаан бий. Улсын яллагч нь шүүхэд шилжүүлж буй хэргийнхээ нотлогдсон байдлаас болон хувийн зан чанар, ажлын арга барил, ажил хэргийн нэр хүндтэй нь холбоотой нөхцөл байдлаас хамаараад шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар өмгөөлөх талтай тохиролцох сонирхолтой байдаг байна.

Хэргийн нотлох баримт сул байх

Энэ нь прокурорыг ял тохиролцоход түлхдэг үндсэн шалтгаан юм. Сулхан нотолгоотойгоор илүү хүнд гэмт хэрэгт шүүгдэгчийг яллах гэж оролдох нь шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох, шүүгдэгчийг цагаатгахад хүргэх өндөр эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл прокурорын 100 хувийн ялагдлаар шүүх хуралдаан өндөрлөж болох юм. Тэгснээс шүүгдэгч үйлдсэн болох нь хангалттай тогтоогдож буй арай хөнгөн гэмт хэрэгт, эсвэл илүү цөөн үйлдэлд яллах нь найдвартай бөгөөд

² Milton Heuman, Plea bargaining; The Experiences of Prosecutors, Judges, and Defence Attorneys, University of Chicago Press, Chicago, 1978, p. 32.

³ J. Michael Thompson, “Caseload Pressure Theory”, unpublished paper, 1985

хэрэв уг гэмт хэргийг үйлдсэн болохоо шүүгдэгч өөрөө хүлээхээр ял тохиролцож чадвал шүүх хуралдаангүйгээр хэргийг төвөг багатай шийдвэрлэх бүр ч таатай нөхцөл прокурорт бүрэлдэх юм. Өөрөөр хэлбэл тодорхой гэмт хэргийг үйлдсэн шүүгдэгчийн гэм бурууг нотлох яллах талын баримт хангалтгүй тохиолдолд улсын яллагч шүүгдэгчийг хуулийн илүү хөнгөн зүйл, хэсэгт заасан гэмт хэрэг, эсвэл арай цөөн үйлдлийг үйлдсэн болохоо хүлээн зөвшөөрсөн тохиолдолд анх төлөвлөж байсан хэрэгтээ түүнийг яллахгүйгээр тохиролцох гэсэн үг. Ингэснээр прокурор шүүгдэгчийг бодит байдал дээр үйлдсэн байж болзошгүй хэрэгт нь яллах боломжоо алдаж буй боловч шүүгдэгч цагаадаж хэрэг хэрэгсэхгүй болохоос аврагддаг.

Яллах талын баримт хангалтгүй гэдэг нь хэргийн шууд гэрч байхгүй, олдоогүй, гэрч зөв мэдүүлэхгүй байгаа, эсхүл зайлсхийж буйгаас гадна хохирогч тодорхой шалтгаанаар гомдол, мэдүүлэг гаргахаас татгалзсан, хэргийн газрын үзлэг, шинжилгээгээр тодорхой зүйл илрээгүй байх тохиолдолд яллах баримтууд илт дутагдаж эхэлдэг. АНУ-ын прокурорууд сул баримттай найдваргүй хэргийн тоонд мөрдөн байцаах байгууллагаас хэт яллах талаас нь шалгаж цагаатгах болон хөнгөрүүлэх баримтуудыг орхигдуулсан хэргүүдийг оруулдаг бөгөөд прокурорыг шүүх хурал дээр ялагдах, хэрэг унагаахад хүргэдэг эрсдэлтэй гэж үздэг юм байна.

Гэрчүүд мэдүүлгээр нь илчлэгдсэн гэмт хэрэгтнүүд өс хонзон авахаас мөн шүүх, цагдаад олон удаа дуудагдахаас төвөгшөөж мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх тохиолдол элбэг. Мөн хохирогчид ч дээрх шалтгаан болон гэмт халдлагын үйл баримтыг олон удаа давтан санаж, ярьснаар сэтгэл санаа нь таагүйтэх, дахин дахин сэтгэлийн хямралд автахаас эмээж мэдүүлэг өгөхөөс татгалздаг нь прокурорын ажлыг хүндрүүлж яллах итгэл үнэмшилд нөлөөлснөөр тэд ял наймаацахыг илүүд үзэхэд түлхдэг бас нэг шалтгаан болдог байна.

Хоорондоо дотно харьцаатай хохирогч, шүүгдэгч бүхий хэрэг дээр хохирогч холбогдогчийн эсрэг тууштай мэдүүлэг өгөх нь тун ховор. Энэ төрлийн гэмт хэргүүдэд ихэвчлэн бага насны, насанд хүрээгүй хохирогч бүхий хүчиндэх төрлийн гэмт хэргүүд, гэр бүлийн хүчирхийллийн элемент агуулсан хэргүүд хамаардаг.

Бусад шалтгаан

Прокурорын ажлын хэт ачаалал нь түүнийг зарим хэргүүд дээр өмгөөлөгчтэй ял тохиролцож хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд хүргэдэг гэж судлаачид үздэг. АНУ-д хэргийг эцэслэн шийдвэрлэх сүүлчийн шүүх хуралдаанаас өмнө хуралдааны өмнөх ажиллагаа гэж нэрлэгддэг хэд хэдэн жижиг бэлтгэл хуралдаануудыг хийж шүүх хуралдаанаар шинжлэн судлах нотлох баримтын болон мэдүүлэг өгөх гэрч, хохирогч, бусад оролцогчдын нэрсийг хэлэлцэж тогтдог. Заримдаа тэдгээрийг урьдчилан байцааж өгөх мэдүүлгийн хэргийн ач холбогдлыг үнэлчихсэн байдаг. Үүнээс гадна оролцогч нараас байнга ирүүлдэг хүсэлт, гомдлыг мөн энэ хуралдаануудаар шийддэг.

Прокурор энэ бүх хуралдаан, уулзалтуудад оролцохын хажуугаар тухайн хэргийн талаар хууль зүйн судалгаа хийж хэргийг эцэслэн шийдвэрлэх шүүх хуралдаанд бэлтгэх гээд асар их ачаалалтай байдгаас хэрэг бүр дээр энэ процессыг бүрэн явуулах боломж тун багатай.

Ачааллыг бууруулах боломжуудыг нэг нь зарим хэргүүд дээр шүүгдэгчийн өмгөөлөгчтэй ял тохиролцох ажиллагаа явуулж хэргийг шүүх хуралдаан хийхгүйгээр шийдвэрлэх явдал боловч ял тохиролцох ажиллагаа ч талуудын сэтгэл зүйн бэлтгэл, мэдлэг чадварыг сорьсон багагүй хугацаа шаардсан бас чиг амаргүй ажил юм.

Олон жил өмгөөлөл явуулсан, энэ ажиллагааны талаар хангалттай туршлага бүхий өмгөөлөгч нар прокурорын ял тохиролцох тухай саналыг тэр бүр шүүрэн авдаггүй, тэр тусмаа ээдрээ, төвөг бүхий хэрэг дээр прокурорын талд шүүгдэгчийг яллах баттай баримт байгаа эсэхийг мэдэхээс нааш ялын тохироо хийдэггүй. Ийм ч учраас зарим хэрэг дээр шүүх хуралдааны өдөр хүртэл, бүр тангарагтны бүрэлдэхүүн сонгогдож шүүхэд гаргах нотлох баримтуудыг тохирох (энэ нь шүүх хуралдааны яг өмнөх үе) үед л зарим баримтуудын агуулга ил болж өмгөөлөгч болон прокурор хэргийн талаар баримжаатай болж шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар тохиролцох тохиолдол ч бий. Ингэж цагийг тулгамдуу хийсэн тохироо

нь мэдээж их цаг, хугацаа зардал хэмнэдэггүй.

Ажлын хэт ачаалал нь хэргийн зарим хэсгийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх гол шалтгаан болдог гэдгийг прокурорууд хүлээн зөвшөөрөх дургүй байдаг ажээ. Тэдний тайлбарласнаар талууд тохиролцох байдлаар шийдвэрлэх нь эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим, эрүүгийн хууль, байцаан шийтгэх хуулийн зорилт, зорилгод илүү нийцэх эрүүгийн хэргүүд байдаг бөгөөд тэдгээрийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь прокурорын ажлын ачааллыг зөвхөн тэнцвэржүүлэх ач холбогдолтой л гэж үздэг. Тэгээд ч яллах болон өмгөөлөх талууд хоёул сэтгэл ханамжтай үлддэг, илүү шударга шийдвэр гардаг зэрэг наад захын давуу талууд байдаг гэж прокурор үздэг юм байна.

Иймээс яллагдагч, шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар талууд тохиролцох стандартыг илүү зөв тогтоож үр дүнтэй хэрэглэх ажлыг зохион байгуулахыг прокурорын байгууллагын чухал зорилтын нэг гэдэг ажээ.

Прокурорын ажлын үзүүлэлтэд хамгийн сөрөг нөлөөтэй зүйл бол аль ч улс оронд шүүгдэгч цагаадах явдал. Ямар ч прокурор үйл ажиллагаандаа энэ гологдлыг гаргахгүй ажиллахыг чухалчилдаг. Мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн, хэрэгт цугласан нотлох баримт хэргийг шийдвэрлэхэд хангалттай биш, гэмт хэргийн зүйлчлэл тохироогүй зэрэг манай практикт хэргийг мөрдөн байцаалтад буцаах, эсвэл зүйлчлэлийг залруулах үндэслэл болдог нөхцөл байдлын үед АНУ-ын эрүүгийн байцаан шийтгэх практикт шүүгдэгчийг цагаатгаж хэргийг прокурорт буцаадаг.

Шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол ховор, хэрвээ хэргийг хэрэгсэхгүй болгох шаардлагатай бол прокурор анх үүсгэсэн хэргээ өөрөө хэрэгсэхгүй болгодог ажээ. Иймээс прокурорууд алдаа гаргахгүйн тулд ял тохиролцох нь илүү эрсдэл багатай гэж үздэг болох нь ойлгомжтой юм.

Гэвч энд бас нэг нөхцөл байдлыг тооцож үзэх нь зүйтэй. Энэ нь илүү ноцтой олны анхаарлыг татсан хэргүүд дээр ял наймаацаж шүүгдэгчид илүү хөнгөн ял санал болгох нь прокурорыг мэргэжил нэгт нөхдийн болон олон нийтийн зүгээс түүнийг “зөөлөн прокурор” гэж шүүмжлэхэд хүргэх бий гэж эмээдэг.

АНУ-ын муж улсуудын тал орчим хувьд нь сонгуулиар прокуророо сонгодог учир олон нийтийн санаа бодлыг заавал ажилдаа харгалзаж тооцохоос өөр аргагүй байдаг. Энэ нь мөн прокурорын ял тохиролцох ажиллагааны явцад ч илэрдэг. Прокурорын нэр хүнд олон нийтийн дунд, дээд шатны прокуроруудын дунд ямар байгаас албан тушаалын ахиц, дэвшлийн асуудал нь хамаарах нь тодорхой учир олны зөвүүцэл, жигшлийг төрүүлсэн хэргүүд (notorious), олонд нэртэй хүмүүс холбогдсон эсвэл олон хохирогчтой, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн анхаарлын төвд буй хэргүүд дээр улсын яллагч нар ял наймаацхаас зайлсхийх нь олонтаа.

Хашир туршлагатай прокурор ямар хэрэг дээр тохиролцоо хийх, ямар хэргийг шүүх хуралдаанд хүргэх үү гэдгийг сайн мэддэг, энэ асуудлаар зөв голч байр суурийг олж баримталж сурсан байдаг. Харин шинэ залуу прокурорууд хэрэг бүрийг шүүх хуралдаан хүргэж цэвэр мэтгэлцээний зарчмаар ажиллаж шүүгдэгчид өндөр ял санал болгож ажлаа эхэлдэг боловч хэд хэдэн удаа хэрэг нь унасны дараа дадлага, туршлага аажмаар сууж эхлэн улмаар хуучин хашир прокуроруудын дээр дурьдсан барицыг олж авдаг.

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх прокурорын хүсэл сонирхлыг өдөөдөг нэг хүчин зүйл бол прокурор, өмгөөлөгч хоёрын тохироог хэдийгээр шүүгч хэвээр батлах албагүй боловч энэ журмаар шүүхэд ирсэн хэргийн бараг л 100 хувьд нь шүүгч тохироог хүлээн авч тохиролцсон зүйлчлэл, ялд өөрчлөлт оруулдаггүй.

Тухайн хэргийн хувь заяа, шүүгдэгчид оногдуулах ялыг нэг ёсондоо прокурор шийдэж, хэргийн хувь заяаг гартаа атгаж буй нь шүүн таслах ажиллагааг зарим талаар хэрэгжүүлж буй сэтгэлгээ төрүүлдэг явдал. АНУ-ын дээд шатны прокурорын байгууллагууд үүнийг прокуророос хэргийн стандартыг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмэр, бүр мэргэжлийн үүрэг, хариуцлага гэж үзэж сэтгэл хангалуун байдаг ажээ.

Өмгөөлөгчийн оролцоо (The Defence's Objectives)

Хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын гүйцэтгэх үүрэг, оролцоотой танилцах явцад өмгөөлөгчийн эзлэх байр суурь нэлээд тодорхой болсон. Мэдээж шүүгдэгчийн гол зорилго нь үйлдсэн хэрэгтээ аль болох хамгийн бага ял шийтгүүлэх, өмгөөлөгчийн зорилго үүнд нь хууль зүйн туслалцааг мэргэжлийн түвшинд үзүүлэх явдал. Гэвч өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчдээ шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлүүлэх нь зохих эрсдэлийг үргэлж агуулж байдаг, тухайн гэмт хэрэгт гэм буруутайд шүүх тооцсон тохиолдолд тохиролцож авах ялаас илүү хүнд ялаар шийтгүүлж болохыг тайлбарласны дараа цагаадах боломжтой зарим хэргийн шүүгдэгчид ч шүүх хуралдаанаар орж азаа үзсэнээс прокурортой тохиролцсон нь дээр гэж бодлоо өөрчлөх нь бий.

Өмгөөлөгч гэм буруугийн талаар ямар мэдэгдэл хийх талаар шийдвэр гаргахдаа хэрэгт цугласан нотлох баримт, хэргийн бодит үйл баримтаас гадна оролцогчид, прокурор, тэр бүү хэл хэргийг хянаж буй шүүгчийн зан авир, арга барил, мэргэжлийн ур чадварыг судлан үзэж шүүгдэгчтэй өөрсдийн давуу тал, сул талыг шүүн ярилцаж алдаа, оноо, эрсдэлээ дүгнэн хэлэлцдэг. Ингэхдээ “хэрэв шүүх хурал хийвэл прокурор ямар үйл баримтыг нотолж чадах вэ” гэдэгт өмгөөлөгч гол анхаарлаа хандуулдаг. Энэ талаар өмгөөлөгч шүүх хуралдааны өмнө шүүхэд хийгддэг ажиллагааны үеэр, ихэвчлэн шүүх хуралдаанаар шинжлэн судлах нотлох баримт гаргаж өгөх үеэр тодорхой баримжаа авах боломжтой.

Гэрчүүдийг урьдчилан байцаах болон гомдол, хүсэлтийг шийдвэрлэх олон жижиг шүүх хуралдааны үеэр ч энэ талаар мэдээлэл авч болдог. Өмгөөлөгч нэгэнт прокурорын байр суурь, түүнд буй гол нотолгоо, мөн сул талыг оновчтой таамагласнаар гэм буруугийн асуудлаар наймаацах боломж бүрдлээ гэсэн үг. Өмгөөлөгч доорх шалтгаануудаар ял тохиролцох сонирхолтой байдаг.

Шүүх хуралдааны эрсдэл

Өмгөөлөгч прокурорын байр суурийн талаар баримжаатай болно гэсэн нь хэрэг хэрхэн шийдвэрлэгдэхийг мэдчихэж байна гэсэн үг огт биш юм. Хэрэг хэрхэн шийдвэрлэгдэхийг хэн ч яг таг хэлж чадахгүй, прокурор ч үүнийг мэдэхгүй.

Өмгөөлөгч прокурорын байр суурь, түүнд буй яллах баримтуудыг мэдлээ ч тангарагтан тэдгээр баримтыг яаж үнэлэхийг урьдчилан мэдэх тун хэцүү, тангарагтан гэм буруугийн асуудлаар шийдвэр гаргасны дараа шүүгч ямар ял шийтгэхийг таамаглах бараг боломжгүй байдаг (АНУ-д шүүгдэгч тухайн гэмт хэрэгт гэм буруутай эсэхийг ард түмний төлөөлөл гэх тангарагтан нар шийдвэрлэж шүүгч шүүх хуралдааныг даргалж хуульчийн хувьд шүүгдэгчийн гэм бурууд тохирсон ял сонгох үүрэгтэй). Нэгнийхээ үр дүнгээс хамаарсан шат дараалсан шийдвэрүүдийг бүгдийг нь онож таамаглана гэдэг тун бүтэшгүй юм.

Үүнээс гадна хэдийгээр өмгөөлөгч тухайн хэрэг, шүүх хуралдааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж өмгөөллийн тактик, төлөвлөгөөгөө сайн боловсруулсан байсан ч шүүгдэгчийн сэтгэл зүйн бэлтгэлээс бас маш их зүйл хамаардаг. Зарим шүүгдэгч прокурор алдаа гаргах, тангарагтан, шүүгч нарт эерэг сэтгэгдэл төрүүлж чадах боломжид найдаж прокурортой тохироход яарахгүй байхад зарим шүүгдэгч өмгөөлөгчөө яаруулж тэвдүүлэн ял тохиролцохыг урьтал болгодог.

Бүр зарим хэт хашир шүүгдэгч нар шүүх хурлаар хэргийг хэлэлцсэн бол цагаатгагдах ч найдвар байсаар байхад азаа үзсэнээс өөрийгөө гэм буруутайг хүлээн зөвшөөрч багахан хэмжээний торгууль, эсвэл их биш хугацаагаар баривчлагдах, ялаа тэнсүүлэх байдлаар асуудлыг дуусгах нь зүйтэй гэж үзэх нь ч бий. Дээр дурьдсан нөхцөл байдлын улмаас өмгөөлөгч тэр бүр шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцүүлж азаа үзэх нь эрсдэлтэй гэж үзэж прокурортой аль болох шүүгдэгчид ашигтай хувилбараар прокурортой тохироонд хүрч хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх сонирхолтой болдог байна.

Бусад оролцогч нарын шахалт

Өмгөөлөгч нь хэдийгээр өөрийнхөө үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хуульд заасан бүхий л арга хэрэгслээр хамгаалах үүрэгтэй боловч ЭБША-ны оролцогчийн хувьд тухайн хэрэг дээр ажиллаж буй хуульчдын нэг болж тэдгээрийн зорилт, зорилготой нийцэж ажиллах хэрэг гардаг. Өөрөөр хэлбэл шүүгч, прокурор болон хохирогч, шүүгдэгчийн бусад өмгөөлөгч нартай үг хэлээ ололцож байх хэрэгтэй байдаг. Судлаач Хьюманы тэмдэглэснээр хэрэгт ач холбогдол багатай зүйлийг тодруулахаар олон хүсэлт гарган бусад оролцогч нартаа яршиг, төвөг уддаг, ялихгүй зүйлээр дээш доош гомдол гаргаж хэл ам хийдэг өмгөөлөгчид прокурор, шүүгч тун дургүй байдаг бөгөөд түүний эсрэг тэдний санаа нэгдэхэд хүргэвэл түүний үйлчлүүлэгчид тун чиг ашиггүйгээр тусдаг талаар бүтээлдээ дурьджээ.⁴

Нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх хуулиар олгогдсон эрх бүхий албан тушаалтан прокурортой өмгөөлөгч дайсагнасан харьцаа үүсгэвэл түүнд хэргийн гол яллах баримтуудтай танилцах боломж тодорхой хэмжээгээр хязгаарлагдаж үндсэндээ хаалттай болж шүүгдэгчид ашигтай өмгөөлөх талын нотлох баримтуудыг цуглуулахад прокурортой хамтран ажиллах боломжоо алдана гэсэн үг. Ер нь ажлын хэсгийн зүгээс (системийн зүгээс) учруулах дарамтыг багасгая гэвэл өөрийн зүгээс системд шахалт бага үзүүлэх шаардлагатай болдог. Байцаан шийтгэх ажиллагааны бүх оролцогч нараас хамгийн их хараанд өртдөг, байнгын анхааралд байдаг оролцогч бол яахын аргагүй шүүгдэгчийн өмгөөлөгч бөгөөд бусад оролцогчид тодорхой зорилготой түүнд нөлөөлөх сонирхолтой байдаг. Өмгөөлөгч тэдний алинд ч тал алдахгүй боловч хэт автагдахгүй байж чадсан тохиолдолд хэргийн оролцогчдын дунд тэнцвэртэй харьцаа тогтдог. Өмгөөлөгч аль нэг тал руу хувирамтгай бол тухайн хэрэг бодитой шийдвэрлэгдэхэд оруулах хувь нэмэр нь эргэлзээтэй болж улмаар өмгөөлөгчийн ажил хэргийн нэр хүнд унахад хүрдэг. Өмгөөлөгч нь байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчтой харьцахдаа ноён нуруу алдахгүй байх нь тун чухал болохыг АНУ-ын хууль судлаач Розетт Кресси тэмдэглэхдээ “...өмгөөлөгч нь урт саваа бариад олсон дээр тэнцвэрээ олон явж буй акробатчинтай яг ижил бөгөөд түүний хөндлөн барьсан савааны нэг үзүүрт хамтын ажиллагаа нөгөө үзүүрт мэтгэлцэн тэмцэл байрладаг. Акробатчин аль нэг тийш хэт хазайвал унадгийг өмгөөлөгч мэддэг, тэнцвэрийг мэдэрдэг байх ёстой...”⁵ гэж тэмдэглэжээ. Тиймээс тухайн хэргийн эргэн тойронд тогтсон тодорхой уур амьсгал, байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын хандлага зэргийг өмгөөлөгч тооцож үзэж өмгөөлүүлэгчийнх нь эрх ашигт хэт сөрөг нөлөөтэй биш л бол дагалдах өнгө аястай байхаас өөр аргагүй байдалд байдаг. Тухайлбал прокурор, шүүгч нарын хэргийг аль болох бага хугацаанд шийдвэрлэх эрмэлзлэлийг өмгөөлөгч ямар нэг хэмжээгээр хүлээж авахаас өөр аргагүй болдог.

Өмгөөлөгчийн ажлын ачаалал

Шүүгдэгчийн хувьд өөрт холбогдсон хэргийг аль болох өөртөө ашигтайгаар түргэн шийдвэрлүүлэхийг хүсэхээс биш өмгөөлөгч, шүүгч, прокурор ажлын ачаалалтай байгаа эсэх нь тэдэнд огт сонин биш билээ. Тийм ч учраас шүүгдэгч нь өөрийн өмгөөлөгчөөсөө хэрэг дээр няхуур нямбай бөгөөд хүч хөлс, цаг хугацаа зарж ажиллахыг шаардаж хүсдэг. Өмгөөлөгчид ч аль болох чадал чинээгээрээ үйлчлүүлэгчээ сэтгэл өндөр үлдэхээр өмгөөллөө явуулахыг хичээдэг.

АНУ-д байдаг public defender буюу төрийн өмгөөлөгч нарын хувьд шүүгч, прокурор нарын адил хэрэгт дарагдаж байдаг тул хэргийг аль болох түргэн дуусгахыг боддог. Гэхдээ мэдээж үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхлыг хөсөрдүүлж өөрийн нэр хүнддээ сэв суулгахыг бодохгүй нь лавтай. Ер нь нийт өмгөөлөгч нарын хувьд ажлын туршлагатай нь холбоотой дараах зүй тогтол ажиглагддаг. Шинэ залуу өмгөөлөгч хэрэг бүрийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж прокурортой нэгийгээ үзэхэд бэлэн, өөрийн үйлчлүүлэгчийнхээ дүрд хувилж эцсээ хүртэл

⁴ Milton Heuman, Plea bargaining: The Experiences of Prosecutors, Judges, and Defence Attorneys, University of Chicago Press, Chicago, 1978, p. 103.

⁵ Arthur Rosset and Donald C. Cressy, Justice by Consent, Lippincott, Philadelphia, 1976, pp. 85-86 and 133-134.

тэмцэх эрмэлзэлтэй, болбол хэрэг бүрийг хэрэгсэхгүй болгох, шүүгдэгчийг цагаатгуулчих санаатай байж, ялах боломжгүй хэрэг, гарах гарцгүй нөхцөл байдал байдаггүй гэдэгт итгэж байдаг. Хэсэг хугацаанд ажиллаж хэд хэд ялагдаж хал үзэж халуун чулуу долоосны эцэст ихэнх тохиолдолд шүүгдэгч нар гэм буруутай байдгаас гадна тэдний үг бүрт итгэх нь алдаанд хүргэдэг, ямар ч гарцгүй “тов тодорхой” хэрэг гэж байдаг гэдгийг ойлгосны эцэст шүүгдэгчийг цагаатгуулж чадаагүй ч илүү хөнгөн шийтгүүлнэ гэдэг бас ялалт юм гэдгийг ойлгодог болдог. Үүний дараачийн шат нь илүү хөнгөн ял шийтгэлд тэр бүр их хүч хөрөнгө, зардал шаардсан халз мэтгэлцээнээр биш өөрийн ажлын туршлага, нэр хүнд, харьцаа холбоонд түшиглэн харилцан ойлголцол, тохиролцоогоор хүрч болохыг ойлгож ял тохиролцох асуудал үндсэндээ үйл ажиллагааных нь гол арга болж зөвхөн үнэхээр прокурор яагаад ч тохиролцохыг хүсдэггүй дээр дурдсан зарим хэргүүд дээр л шүүх хуралдаан хийдэг болдог байна.

Шүүхээс хамаарах хүчин зүйлс(The Court's Objectives)

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж буй үед шүүхийн гүйцэтгэх гол үүрэг шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар хийсэн талуудын тохироо хуульд нийцэж буй эсэх, хэрэг бодитой, шударга шийдвэрлэгдэж буй эсэхэд тавих хяналт юм. Энэ нь ял шүүгдэгчийн хувийн байдал, гэм буруугийн хэр хэмжээнд тохирч буй болон ял тохиролцохдоо Америкийн барын холбооноос гаргасан стандарт⁶ баримталсан эсэхийг шалгана гэсэн үг юм. Гэвч шүүх талуудын ял тохиролцохыг хязгаарлах хавчих бодлого баримтлах ёсгүй. Хэдийгээр шүүгч шүүхээр орж ирж буй хэргийн талаар, шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар аль хэдийн өөрийн дотоод итгэл, үнэмшилтэй болсон байдаг боловч хуралдаан дээр үүнийгээ харуулах ёсгүй байдаг. Хэрэв шүүгч тухайн хэрэгт хэрхэн хандаж байгаа нь шүүх хуралдааны өмнөх ажиллагаанаас илт байх юм бол талууд ял тохиролцож эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах эрмэлзэл багасаж санаачилга гаргаж энэ талаар тохиролцоонд хүрэх нь цөөрөх болно. Энэ утгаараа ял тохиролцох нь багасаж аль болох шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлүүлэх хандлагатай болж энэ хэмжээгээр шүүхийн ачаалал эрс нэмэгдэнэ гэж судлаачид үздэг ажээ. Ял тохиролцохыг шүүхээс дэмжих гол хэлбэр нь хэргийн талаар өөрийн дотоод итгэлийг хэрэг эцэслэн шийдвэрлэгдтэл бусдад ил гаргахгүй хадгалах, шүүгдэгч өөрийгөө гэм буруугүй гэсэн мэдэгдэл гаргаж шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцүүлсэн боловч түүний гэм буруу нь бүрэн тогтоогдсон тохиолдолд ял тохиролцсон бол авах байсан ялаас илүү хүндрүүлж шийтгэх явдал гэж АНУ-д үздэг ажээ.

Ял тохиролцох процесс (The Process of Plea Bargaining)

АНУ-д ял тохиролцох процедурыг албан ёсоор хуульчилж өгөөгүй, энэ асуудлыг прокурор, өмгөөлөгчид уулзах боломж гарсан үед хаана ч хамаагүй, тухайлбал шүүхийн цайны газар кофе хамт уух зуураа, эсвэл шүүхийн байрны гудамж, хонгилд тааралдсан байсан ч ярилцдаг. Талуудын аль нэг нь жишээлбэл шүүгдэгчийн өмгөөлөгч прокурорт маш энгийнээр “Жонсоны хэргийг хэлэлцэх дөхөж байна. Энэ хэрэг дээр зарим талаар бид хамтраад ажиллачих боломж гарах бол уу гэж найдаж байна” гэж хэлэх байдлаар санаагаа илэрхийлснээр тохиролцооны эхлэл тавигдах нь түгээмэл.

Прокурор ямар ч тохиолдолд өмгөөлөгчийн саналыг урьдчилан сонсдог бөгөөд энэ үеэс эхлэн талуудын хооронд мөрийтэй тоглоомчид мөрий тавихын нэгэн адил өөрийн бодит байдлыг нууж эсрэг талынхаа нөхцөл байдал, санаа бодлыг мэдэх оролдлого эрчимждэг. Энэ талаар зохих хэмжээний баримжаатай болмогч эсрэг талд өөрийнхөө нөхцөл байдлыг давуутай мэтээр ойлгуулж айлган сүрдүүлснээр өөрт ашигтай тохироонд буулгаж авахыг оролддог. Энэ процесс хэд хэдэн уулзалтыг дамжин зарим тохиолдолд хэдэн сараар ч үргэлжилж

⁶ ABA Commission on Minimum Standards for Criminal Justice, Standards Related to Pleas of Guilty, ABA, Chicago, 1968, pp. 36-37.

болох бөгөөд талуудын сэтгэл зүйн бэлтгэл, хэн сайн тоглож байгаагаас хамаарч хэн нэгэнд нь илүү ашигтай байдлаар зохицож дуусдаг. Анхандаа албаны бус байдлаар эхэлсэн уг яриа шүүх хуралдааны өмнөх шатны жижиг хуралдаанууд дээр албаны өнгө аястай болж болно. Харин хохирлын хэмжээ багатай, нийгмийн хор аюулаар их биш, тохиолдлын чанартай, садан төрлийн хүмүүсийн хооронд гарсан хэргүүд буюу “хог хэрэг” гэж АНУ-ын хуульчид хэлдэг хэргүүдийн тухайд энэ процесс их уддаггүй, анх хэн нэг нь санал тавьж нөгөө тал нь хүлээн авснаар яриа дуусгавар болдог.

Саналыг ихэвчлэн шүүгдэгчийн өмгөөлөгч тавих бөгөөд прокурорын хариу болгож “энэ л хамгийн боломжтой” гэсэн нэрээр нэлээд хатуу саналыг өмгөөлөгчид хэлдэг. Энэ нь ихэвчлэн шүүгдэгчид таалагддаггүй бөгөөд өмгөөлөгч уг саналыг хөнгөрүүлж өөрчлөх арга зам байна гэж үзвэл прокурортой хэлэлцээгээ үргэлжлүүлдэг. Эцэст нь прокуророос үнэхээр хүлээн авахаас өөр аргагүй бодитой саналыг тавилаа гэж өмгөөлөгч үзвэл прокурорыг орхиж өөрийнхөө үйлчлүүлэгчтэй ажиллаж эхэлдэг. Шүүгдэгч алгаа ташаад хүлээгээд авдаг санал гэж бараг байдаггүй ба олон таагүй боломжоос аль гайгүйг нь сонгох л тавилантай байдаг. Шүүгдэгч сонголттой хийж чадахгүй байгаа тохиолдолд өмгөөлөгч өөрөө сонголтыг хийж уг сонголт хамгийн зөв болохыг үйлчлүүлэгчдээ ятгаж ойлгуулах л үлдэнэ. Ингэхдээ өмгөөлөгч нар итгүүлж ухуулах, бага зэргийн заль хэрэглэх, сүрдүүлэх зэрэг янз бүрийн арга хэрэглэж эцсийн дүнгээрээ шүүгдэгч нараар зөвшөөрүүлсэн л байдаг. Ер нь АНУ-ын хуульч нарын дотор үйлчлүүлэгчдээ өөрийн сонголт зөв болохыг итгүүлж үнэмшүүлж чадахгүй байгаа өмгөөлөгч шүүх хуралдаан дээр тангарагтан нарыг үйлчлүүлэгчээ гэм буруугүй гэдэгт итгүүлнэ гэдэг бүтэшгүй хэрэг гэсэн яриа тархсан байдаг.

АНУ дахь ял наймаацах ажиллагааны талаарх ерөнхий ойлголт, яллах болон өмгөөлөх талуудын үүрэг, оролцоог товч тайлбарлалаа. Энэ сэдвийг бичигч сэтгүүлийн дараачийн дугаарт талуудын хооронд хийгддэг тохиролцооны хэлбэр, төрөл (The Product of plea bargaining), хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүхийн хяналт (Judicial review and acceptance of pleas) болон Америкийн Барын Холбооноос энэ талаар гаргасан стандартыг толилуулах болно.